



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 0111 - 2024/15

Сүхбаатар сум

Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
ажлын албаны Санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 09 дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга СХШУАБ Т.Одсүрэн ахлан дотоод аудитор Х.Батбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Ерөө сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны (цаашид сумын Ерөө сумын ИТХ гэх)-ын 2024 оны 3 дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Ерөө сумын ИТХ нь улсын бүртгэлийн 3763781 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130254001 дугаартай үндсэн данс, 100130254401 дугаартай нэмэлт дансыг ашиглаж байна.

1.5. Ерөө сумын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Болормаа, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Д.Золзаяа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Ерөө сумын ИТХ нь улс төрийн албан тушаалтан 1, төрийн захиргааны албан хаагч 3, гэрээт ажилтан 1 нийт 5 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

4324001127

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувь, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 96.0 хувь, сумын ИТХ-ын даргатай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт эхний 3 дугаар улирлын байдлаар 90.6 хувьтай хэрэгжүүлсэн байна.

2.1.2 ИТХ-ын нарийн бичгийн даргын тушаалаар баталгаажсан захиргааны байгууллагын захиргааны актад утга, агуулгын алдаагүй бодит нөхцөл байдлыг тогтоосон, эрх зүйн үндэслэл хэсэгт нарийвчилсан зохицуулалтай хуулийн заалт, болон хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актын зүйл заалтыг ашиглахгүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

2.1.3 Сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2024 оны эхний хагас жилийн байдлаар 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 253,213.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 241,642.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Хүснэгт 1.
төгрөгөөр)

(мянган

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	253,213.1	162,772.9	90,440.2	64.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,931.1	162,772.9	80,158.2	67.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242,931.1	154,017.9	88,913.2	63.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,474.6	113,135.0	37,339.6	75.2
210101	Үндсэн цалин	49,500.0	47,150.0	2,350.0	95.3
210102	Нэмэгдэл	49,500.0	39,645.6	9,854.4	80.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,533.0	(1,533.0)	-
210104	Урамшуулал	11,590.2	-	11,590.2	-
210105	Гэрээт ажлын хөлс	39,884.4	24,806.5	15,077.9	62.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,616.5	13,891.5	4,725.0	74.6
210201	Тэтгэврийн даатгал	12,661.2	9,355.8	3,305.4	73.9

210202	Тэтгэмжийн даатгал	1,489.5	1,069.9	419.6	71.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	743.4	606.9	136.5	81.6
210204	Ажилгүйдлийн даатгал	743.4	606.9	136.5	81.6
210205	Эрүүл мэндийн даатгал	2,979.0	2,252.0	727.0	75.6
2104	Хангамж, бараа материалын зардал	14,140.0	9,190.4	4,949.6	65.0
210401	Бичиг хэрэг	1,200.0	350.9	849.1	29.2
210402	Тээвэр, шатахуун	10,400.0	7,799.4	2,600.6	75.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	540.0	476.4	63.6	88.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000.0	563.7	1,436.3	28.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,500.0	2,308.0	9,192.0	20.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000.0	989.0	2,011.0	33.0
210602	Тавилга	6,500.0	-	6,500.0	-
210604	Урсгал засвар	2,000.0	1,319.0	681.0	66.0
2107	Томилолт, зочны зардал	1,400.0	140.0	1,260.0	10.0
210702	Дотоод албан томилолт	1,400.0	140.0	1,260.0	10.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,800.0	121.6	2,678.4	4.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000.0	-	2,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	100.0	49.5	50.5	49.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400.0	2.1	397.9	0.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100.0	-	100.0	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	200.0	70.0	130.0	35.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,000.0	15,231.4	28,768.6	34.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000.0	9,901.1	20,098.9	33.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,000.0	5,330.3	8,669.8	38.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,282.0	8,755.0	1,527.0	85.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,282.0	8,755.0	1,527.0	85.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,582.0	8,755.0	827.0	91.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700.0	-	700.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	253,213.1	241,642.1	11,571.0	95.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	253,213.1	241,642.1	11,571.0	95.4
320001	Орон нутгийн төсвөөс	253,213.1	241,642.1	11,571.0	95.4
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	78,869.2	(78,869.2)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5.0	5.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	2.0	2.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	2.0	2.0	-	100.0
620004	Гэрээт ажилтан	1.0	1.0	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5.0	5.0	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	3.0	3.0	-	100.0
650010	Гэрээт ажилтан	1.0	1.0	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.0	1.0	-	100.0

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 162,772.9 мянган төгрөг буюу 64.3 хувьтай байгаа нь Орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилтийг 11,571.0 мянган төгрөгөөр дутуу, урсгал зардал 80,158.2 мянган төгрөгийн гүйцэтгэл байгаатай холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 37,339.6 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 4,725.0 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардал 4,949.6 мянган төгрөгөөр, тавилга эд хогшлын зардлыг 9,192.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 1,260.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,678.4 мянган төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлыг 28,768.6 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 1,527.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөж байх шаардлагатай байна. Учир нь цалингийн болон бараа үйлчилгээний зардлыг хэт өндрөөр төлөвлөсөн нь гүйцэтгэлээр тодорхой харагдаж байна.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд: Өмнөх оны татан төвлөрүүлсэн 203.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч зарцуулсан байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоолт, олголтын байдал

Сумын ИТХ-ын цалин хөлсний тооцооллыг цалингийн дэлгэрэнгүй бүртгэл, НДШ-ийн НД8 дэлгэрэнгүй тайлан болон холбогдох тушаал шийдвэр, цагийн тооцооны бүртгэл зэрэгтэй тулга шалгахад Үндэсний баяр наадам болон сумын 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах болон хурлын ажлын бэлтгэл хангахад илүү цагаар ажилласан гэх үндэслэлээр 4 албан хаагчид нийт 3,377.2 мянган төгрөгийн илүү цагаар ажилласны цалин хөлсний нэмэгдлийг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-ын нэгийн 4 дэх заалттай нийцээгүй байна.

Мөн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны бүтэц орон тоо батлах тухай 2021 оны 29 дугаар тогтоолоор гэрээт ажилтны орон тоонд нягтлан бодогч авч ажиллуулахдаа төрийн үйлчилгээний ТҮМ-7 албан тушаалын ангилал зэрэглэл цалингийн 50 хувиар тооцож ажил хавсран гүйцэтгүүлэх тушаалд захиргааны байгууллагаас захиргааны акт гаргах эрх олгогдсон хууль зүйн заалтыг тодорхой заагаагүй, бодит нөхцөл байдлыг тодорхой тусгаагүй байна.

2.4 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ИТХ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр тендерийн шууд худалдан авах босго үнээс давсан томоохон худалдан авалт хийгдээгүй байна.

2.5. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2023 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитаар бие даасан дүгнэлт гараагүй түүвэрт хамрагдсан ба төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсөв санхүү, бүртгэл тайлагналтай холбоотой 359.9 мянган төгрөгийн илүү тооцож олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх 1 төлбөрийн акт, төсвийг зохистой удирдаагүй төлбөр тооцоог хянаагүйгээс НДШ-ийн 4,467.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл хоцроон байршуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөгдсөнийг тайлант оны хугацаанд зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх явцдаа НДШ-ийн төлбөр тооцоог хянаагүйн улмаас 3 дугаар улирлын байдлаар авлага үүсгэж албан шаардлагаа өгсөн зөрчлийг давтан гаргасан байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Ерөө сумын ИТХ-ын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэл, ИТХ-ын хуралдааны зардал, цалин хөлсний тооцоолол, өр, авлага, бараа материалын бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй зэрэг дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт 1. Үндэсний баяр наадам болон сумын 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах болон хурлын ажлын бэлтгэл хангахад илүү цагаар ажилласан гэх үндэслэлээр 4 албан хаагчид **3,377.2** мянган төгрөгийн илүү цагаар ажилласны цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-ын 5-д "нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажил олгогчийн санаачилгаар ажиллуулахыг хориглоно: 5.1. энэ журмын 4.1-4.4-т заасан тохиолдол" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4-д зааснаас бусад тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар ажиллуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Сумын ИТХ-ын хуралдааны зардлын төсвийн гүйцэтгэлийн тайлан, хурлаар хэлэлцсэн асуудал болон ирцийн бүртгэл зэрэг анхан шатны баримтуудыг санхүүгийн баримтад хавсаргаагүй зарцуулалтыг дэмжих анхан шатны баримтын бүрдэл ханаагүй **5,330.2** мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв бүрдүүлж баталгаажуулсны үндсэн дээр санхүүгийн тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимгэлд 656.5 мянган төгрөг, даатгуулагчаас төлөх НДШ-д 4,009.9 мянган төгрөг нийт **4,666.4** мянган төгрөгийг эдийн засгийн зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 6 сарын 8-ны өдрийн 134 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6 дахь "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу арцуулах шаардлагатай тохиолдолд дээд шатны төсвийн захирагчаас төсөвт зохицуулалт хийх зөвшөөрлийг авч байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ-д **199.0** мянган төгрөгийн авлага үүсгэж бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба

төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх, бүртгэл тайланд бүрэн тусгаж байх шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5. "Үйлс Дэлгэрэх" ХХК-аас төсвийн хөрөнгөөр худалдан авсан **987.0** мянган төгрөгийн хяналтын камер хөрөнгө материалын дансанд орлогоор бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь *“Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө. 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д Аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д бүх орлого,”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг давхар бичилтийн аргаар бүх ажил гүйлгээг бүртгэж байх, зардлаар тайлагнасан хяналтын камерыг данс бүртгэлд орлого авах зөвлөмжийг хүргүүлэв.

Илрүүлэлт 6. ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны бүтэц орон тоо батлах тухай 2021 оны 29 дугаар тогтоолоор гэрээт ажилтны орон тоонд төрийн үйлчилгээний ТҮМ-7 албан тушаалын ангилал зэрэглэл цалингийн 50 хувиар тооцож ЗДТГ-ын нягтлан бодогчид ажил хавсран гүйцэтгүүлэх тушаалд захиргааны байгууллагаас захиргааны акт гаргах эрх олгогдсон хууль зүйн заалтыг тодорхой заагаагүй, бодит нөхцөл байдлыг тодорхой тусгаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь *“Захиргааны актын хууль зүйн үндэслэлд захиргааны байгууллага захиргааны акт гаргах эрх олгогдсон хуулийн зүйл, заалтыг тодорхой заана.”*, Ерөө сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 29 дүгээр тогтоолыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч нарийвчилсан зохицуулалтай хуулийн заалт, болон хуулиар эрх олгосон захиргааны хэмж хэмжээний актын зүйл заалтыг үндэслэж хууль зүйн техникийн зөв ашиглаж хэвших зөвлөмж хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Ерөө сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Ерөө сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **14,560.5** мянган төгрөгийн **6** зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох 13,373.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага, давтан гаргахгүй 987.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:


Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт даалгав.

БИЧСЭН.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД АУДИТОР

 Х.БАТБААТАР

ТАНИЛЦСАН
ЕРӨӨ СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  Э.БОЛОРМАА
НЯГТЛАН БОДОГЧ  Д.ЗОЛЗАЯА